

2026 оны 06 дугаар сарын 19-ны өдөр

**ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванхоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн”, 2 дахь хэсэгт “Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ...”, 7 дахь хэсэгт төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журмыг хуулиар тогтооно гэж тус тус заасан.

Төрийн бэлгэ тэмдэг нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, төрт ёсны уламжлал, үндэсний эв нэгдлийг илэрхийлсэн нийтээр хүндэтгэн дээдлэх үнэт зүйл мөн. Иймд төрийн бэлгэ тэмдгийг зөв, зүй зохистой хэрэглэх эрх зүйн орчныг Ерөнхий боловсролын сургуулиудад өдөр тутмын үйл ажиллагаатай уялдуулан тодорхой болгох нь Үндсэн хуулийн үзэл санаа, төрийн бэлгэ тэмдгийг дээдлэх зарчимтай нийцнэ.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан Төрийн далбааг байнга болон түр хугацаагаар мандуулах байршлыг, мөн хуулийн 25 дугаар зүйлд иргэн, өрх, аж ахуйн нэгж, байгууллага төрийн бэлгэ тэмдгээ дээдлэн хүндэтгэж, төрийн далбаагаа байрлуулах, мандуулах эрх чөлөөг тус тус зохицуулсан боловч хичээлийн жилийн хугацаанд ерөнхий боловсролын сургуулийн орчинд төрийн далбааг хэвшмэл, нэг мөр байдлаар хэрэглэх талаар тусгайлан тодорхойлсон зохицуулалт байхгүй байна.

Практикт ерөнхий боловсролын сургуулиуд төрийн далбааг байрлуулах, мандуулах, сургалт, хүмүүжлийн ажилд ашиглах асуудлыг дотоод журам, тухайн байгууллагын нөхцөл боломжид тулгуурлан харилцан адилгүй хэрэгжүүлж байна. Энэ нь төрийн бэлгэ тэмдгийг дээдлэх хандлага, хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулах, суралцагчдад төлөвшүүлэх хүмүүжлийн агуулгыг тогтворгүй болгох эрсдэлтэй.

Иймд ерөнхий боловсролын сургуулийн орчинд төрийн далбааг хүндэтгэлтэй, зүй зохистой байрлуулж, хичээл, сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаа хугацаанд мандуулах эрх зүйн үндсийг тодорхой болгох, хуулийн хэрэглээний нэг мөр байдлыг хангах, төрийн бэлгэ тэмдгийг дээдлэх соёлыг суралцагчдад төлөвшүүлэх зорилгоор Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ бий болсон байна.

1.2 Практик шаардлага

Монгол Улсын нийт хүн амын 37.1 хувийг хүүхэд, залуучууд эзэлж байгаа нь хүний хөгжил, иргэний төлөвшлийг төрийн бодлогын тэргүүлэх чиглэлд авч үзэх зайлшгүй шаардлагыг илэрхийлж байна.

Боловсролын яамны мэдээллээр улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд нийт 819,907 суралцагч төрийн өмчийн 717, хувийн өмчийн 183 сургуульд суралцаж байгаа нь иргэний төлөвшлийг хангах бодлогыг хэрэгжүүлэхэд ерөнхий боловсролын сургуулийн орчны хамрах хүрээ, нөлөөллийн чадавх өндөр байгааг харуулж байна. Энэ утгаараа сургуулийн орчинд төрийн далбааг зүй зохистой, нэг мөр дадал болох байдлаар хэрэглэх нь Үндсэн хуульд тусгагдсан тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эв нэгдэл зэрэг үнэт зүйлсийг хойч үеийн ухамсарт бодитойгоор төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

Одоогийн хүчин төгөлдөр хууль, эрх зүйн орчинд төрийн далбааг ерөнхий боловсролын сургуулийн орчинд түр хугацаагаар мандуулах, сургалт болон хүмүүжлийн үйл ажиллагаатай уялдуулан хэрэглэх талаарх нийтлэг зохицуулалт байхгүй байгаа тул сургууль бүрд хэрэгжилт харилцан адилгүй үүнээс шалтгаалан төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх арга барил, хүндэтгэлийн соёл, ойлголт жигд бус хэлбэрээр төлөвших нөхцөл үүсэж байна. Энэхүү нөхцөл байдал нь Үндсэн хуульд тунхагласан төрийн бэлгэ тэмдгийг дээдлэх зарчим, хуульд болон бодлогын баримт бичигт тусгагдсан иргэний төлөвшил, эх оронч үзлийг бодитойгоор төлөвшүүлэх зорилттой нийцэхгүй. Иймд ерөнхий боловсролын сургуулиудад хичээлийн жилийн хугацаанд төрийн далбааг түр хугацаанд мандуулах зохицуулалтын хүрээг тодорхой болгох зорилгоор Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Хуулийн төслийн зорилго

Энэхүү хуулийн төслийн зорилго нь төрийн бэлгэ тэмдгийг ерөнхий боловсролын сургуулийн орчинд хичээлийн жилийн хугацаанд хүндэтгэлтэй, зүй зохистой, хэвшмэл байдлаар хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхой болгож, суралцагчдад төрийн бэлгэ тэмдгийг дээдлэх ухамсар, эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэхэд оршино.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванхоёрдугаар зүйлийн үзэл санааг бодит амьдралд хэрэгжүүлэх, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн зохицуулалтыг боловсролын салбарын онцлогтой уялдуулах, хуулийн хэрэглээний тодорхой байдлыг хангахад чиглэнэ.

2.2. Зохицуулах харилцаа

Хуулийн төсөл нь ерөнхий боловсролын сургуулийн орчинд төрийн далбааг байршуулах, түр хугацаагаар мандуулах, дээдлэн хэрэглэхтэй холбогдсон суурь харилцааг зохицуулна.

Хуулийн төсөл нь 2 зүйлтэй байна. Нэгдүгээр зүйлээр Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхий боловсролын сургуульд хичээл, сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаа хугацаанд Төрийн далбааг мандуулна” гэсэн агуулгатай шинэ заалт нэмэхээр, хоёрдугаар зүйлээр хуулийг дагаж мөрдөх хугацааг тогтооно.

2.3. Хамрах хүрээ

Энэхүү хуулийн төсөл нь төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш, ажилтан, суралцагчийн төрийн далбаатай хүндэтгэлтэй хэрэглэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтын хүрээнд хамаарна.

Хуулийн төсөл нь сургуулийн дотоод журмыг бүхэлд нь шинээр тогтоохгүй бөгөөд зөвхөн төрийн далбааг хэрэглэх суурь хэм хэмжээг тодорхой болгож, цаашдын хэрэгжилтийг удирдамж, зөвлөмжөөр нарийвчлан зохицуулах боломжийг нээлттэй үлдээнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар ерөнхий боловсролын сургуулийн орчинд төрийн далбааг хэрэглэх талаарх ойлголт, хэрэглээний нэг мөр байдал сайжирч, төрийн бэлгэ тэмдгийг дээдлэх соёлыг суралцагчдад төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. Мөн сургуулийн өдөр тутмын орчинд төрийн бэлгэ тэмдгийн ач холбогдлыг бодитоор мэдрүүлэх, үндэсний эв нэгдэл, эх оронч үзэл, иргэний ухамсрыг төлөвшүүлэхэд дэмжлэг болно.

Эдийн засгийн үр дагаврын хувьд хуулийн төслийг хэрэгжүүлэхэд шинээр байгууллага байгуулах, орон тоо нэмэх, тусгай бүтэц бий болгох шаардлага үүсэхгүй. Төрийн далбааг байршуулах, мандуулахтай холбоотой зохион байгуулалтын шинжтэй зардлыг тухайн сургуулийн батлагдсан төсөв, одоо байгаа материаллаг нөөцийн хүрээнд үе шаттайгаар хэрэгжүүлэх боломжтой.

Хууль зүйн үр дагаврын хувьд энэхүү төсөл нь Үндсэн хууль болон Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн зорилт, агуулгатай нийцэж, төрийн далбааг ерөнхий боловсролын сургуулийн орчинд хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхой болгоно. Ингэснээр хуулийн зохицуулалтын хийдэл багасаж, хэрэглээний тодорхой байдал нэмэгдэнэ.

Хуулийн төслийн хэрэгжилтийг хангах хүрээнд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон ерөнхий боловсролын сургуулийн удирдлага нь хуульд нийцсэн дотоод зохион байгуулалт, тайлбар, зөвлөмжийг боловсронгуй болгох боломжтой.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванхоёрдугаар зүйлийн 1, 2, 7 дахь хэсэг, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Ардчилсан ёс, шударга ёс...”, үндэсний эв нэгдэл, хууль дээдлэх зарчимтай нийцнэ. Түүнчлэн Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 1, 2, 3, 13, 25, 28 дугаар зүйлд туссан зохицуулалтын зорилт, бүтэцтэй уялдаж, одоо үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтыг тодруулсан нэмэлт зохицуулалт болно.

Түүнчлэн, хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод тусгагдсан үнэт зүйл, зарчимтай нийцэж, боловсролын орчинд төрийн бэлгэ тэмдгийг зүй зохистой, хүндэтгэлтэй, хэвшмэл байдлаар хэрэглэх эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар суралцагчдын эх оронч үзэл, иргэний ухамсар, үндэсний үнэт зүйлийг дээдлэх хандлагыг төлөвшүүлэхэд чиглэж байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан өөр хуульд зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ үүсэхгүй. Хуулийн хэрэгжилтийн явцад шаардлагатай гэж үзвэл сургуулийн орчинд төрийн далбааг хэрэглэх талаар тайлбар, зөвлөмжийн шинжтэй баримт бичгийг холбогдох байгууллагаас гарган хэрэгжүүлж болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

---оОо---